

ХҮН АМЫН БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТАНДАХ ТУРШИЛТЫН СУДАЛГАА

6-9 сар, 2023



АГУУЛГА



ЗУРГИЙН ЖАГСААЛТ	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ӨМНӨХ ҮГ	4
НЭГ. СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ	5
1.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	5
1.3 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ	6
1.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	6
1.5 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	6
ХОЁР. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	8
2.1 СУДАЛГААНЫ ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ	8
2.2 АЛБАН ЁСНЫ БҮРТГЭЛ	9
2.3 САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	11
2.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	12
ГУРАВ. БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛГӨӨН (ИРСЭН)	14
ДӨРӨВ. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ	19
ТАВ. БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ (ЯВСАН)	22
ДҮГНЭЛТ	24
ХАВСРАЛТ А	26
ХАВСРАЛТ Б	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ



ЗУРАГ 2.1.1 ХҮН АМ ЗҮЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ, 2022 ОН.....	8
ЗУРАГ 2.1.2 СУДАЛГААНД ХАМРАГДАГЧИД НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР 2022 ОН.....	9
ЗУРАГ 2.1.3 СУДАЛГААНД ХАМРАГДСАН НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, 2022 ОН.....	9
ЗУРАГ 2.2.1 АЛБАН ЁСНЫ БҮРТГЭЛТЭЙ БАГУУД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2022 ОН.....	10
ЗУРАГ 2.2.2 ХҮН БҮР БҮРТГЭЛТЭЙ (100.0%), 2022 ОН.....	10
ЗУРАГ 2.2.3 БҮГД БҮРТГЭЛГҮЙ (0.0%), 2022 ОН.....	10
ЗУРАГ 2.2.4 БҮРТГЭЛЭЭ ХИЙЛГЭДЭГГҮЙ ГОЛЛОХ ШАЛТГААН, ХУВИАР, 2022 ОН.....	11
ЗУРАГ 2.3.1 БАГИЙН ИРГЭДИЙН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР 2022 ОН.....	11
ЗУРАГ 2.3.2 ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭГЭЭ БАГАСГАСАН БАЙДАЛ, ХУВИАР, 2022 ОН.....	12
ЗУРАГ 2.4.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХУВИАР, 2022 ОН.....	12
ЗУРАГ 2.4.2 БАГИЙН ИРГЭДЭД ХАНГАЛТАЙ ХҮРТЭЭМЖГҮЙ БАЙГАА ҮЙЛЧИЛГЭЭ.....	13
ЗУРАГ 2.4.3 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, 2022 ОН.....	13
ЗУРАГ 3.1 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ИРСЭН ХҮН БАЙГАА ЭСЭХ, ХУВИАР, 2022 ОН.....	14
ЗУРАГ 3.2 БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛГӨӨНӨӨР ИРСЭН ХҮМҮҮС, ХУВИАР ХАМГИЙН ӨНДӨР 5 АЙМГААР, 2022 ОН.....	15
ЗУРАГ 3.3 ТУХАЙН БАГТ СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ИРСЭН ХҮМҮҮС, ХУВИАР 2022 ОН.....	15
ЗУРАГ 3.4 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ИРСЭН ХҮМҮҮС, ХУВИАР, 2022 ОН.....	15
ЗУРАГ 3.5 ИРСЭН АЙМГУУДААР, ХУВИАР, 2022 ОН.....	16
ЗУРАГ 3.6 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ИРСЭН ХҮМҮҮСИЙН ҮНДСЭН ШАЛТГААН, ХУВИАР, 2022 ОН.....	16
ЗУРАГ 3.7 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ШАЛТГААНААР ИРСЭН ХҮМҮҮС, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРААР, ХУВИАР, 2022 ОН.....	17
ЗУРАГ 3.8 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД УУЛ УУРХАЙН САЛБАРТ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭЭР ИРСЭН ИРГЭД, ХУВИАР, 2022 ОН.....	18
ЗУРАГ 3.9 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД МАЛЧНААР АЖИЛЛАХААР ИРСЭН ИРГЭД, ХУВИАР, 2022 ОН.....	18
ЗУРАГ 3.10 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ХҮҮХДИЙН ТЭВЧИШГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭЭР ИРСЭН ХҮҮХЭД (15-17 НАС), ХАМГИЙН ИХ 5 АЙМАГ, ХУВИАР, 2022 ОН.....	18
ЗУРАГ 3.11 СҮҮЛИЙН 3 САР ОТОР НҮҮДЭЛ ХИЙХЭЭР ИРСЭН ИРГЭД ХАМГИЙН ИХ 5 АЙМАГ, ХУВИАР, 2022 ОН.....	18
ЗУРАГ 3.12 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ИРСЭН ОТОР НҮҮДЛЭЭР ИРСЭН ХҮМҮҮСИЙН ҮНДСЭН ШАЛТГААН, ХУВИАР, 2022 ОН.....	19
ЗУРАГ 3.13 СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ИРСЭН ИРГЭДЭЭС БАГТАА ҮЛДСЭН ИРГЭД, ХУВИАР, 2022 ОН.....	19

ЗУРАГ 4.1 ТАНАЙ БАГТ БОГИНО ХУГАЦААГААР ИРЖ БҮЙ ХҮН АМЫН ХӨДӨЛГӨӨН ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ УЧРУУЛЖ БАЙНА УУ? АЙМАГ, ХУВИАР, 2022 ОН	20
ЗУРАГ 4.2 БОГИНО ХУГАЦААГААР ИРЖ БҮЙ ХҮН АМЫН ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ХУВИАР, 2022 ОН.....	20
ЗУРАГ 4.3 ДЭЭРХ АСУУДЛЫГ АРИЛГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААР БАГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖЭЭС ЯМАР НЭГЭН АРГА ХЭМЖЭЭ АВЧ БАЙНА УУ? АЙМАГ, ХУВИАР, 2022 ОН.....	21
ЗУРАГ 4.4 ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖЭЭС ОДОО АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНЭЭС ӨӨР ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХЫГ ИЛҮҮД ҮЗЭЖ БАЙНА ВЭ? ХУВИАР, 2022 ОН.....	21
ЗУРАГ 5.1 ТАНАЙ БАГААС СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ЯВСАН ИРГЭД БИЙ ЭСЭХ, АЙМАГ, ХУВИАР, 2022 ОН	22
ЗУРАГ 5.2 БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛГӨӨНӨӨР ЯВСАН ХҮМҮҮС, ХАМГИЙН ӨНДӨР 5 АЙМГААР, ХУВИАР 2022 ОН.....	22
ЗУРАГ 5.3 ТАНАЙ БАГААС СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ЯВСАН ХҮМҮҮСИЙН ИХЭНХ НЬ ХААШАА ЯВСАН БЭ? ХУВИАР, 2022 ОН.....	23
ЗУРАГ 5.4 ХЭРЭВ БУСАД СУМ, БАГ РУУ ЯВСАН БОЛ ТЭДГЭЭР ХҮМҮҮСИЙН ИХЭНХ НЬ ХААШАА ЯВСАН БЭ? ХУВИАР, 2022 ОН.....	23
ЗУРАГ 5.5 ТАНАЙ БАГААС СҮҮЛИЙН 3 САРЫН ХУГАЦААНД ЯВСАН ИРГЭДИЙН ҮНДСЭН ШАЛТГААН, ХУВИАР, 2022 ОН	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ



ОУШХБ	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ТӨШГ	Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар
ХАОСТХ	Хүн ам, орон сууцны тооллогын хэлтэс
ДТМ	Хөдөлгөөнийг тандах матриц
НШИ	Нүүлгэн шилжүүлсэн иргэд

ӨМНӨХ ҮГ



Байгаль, цаг уур, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, бэлчээрийн хомсдол зэргийн нөлөөлөл нь Монголчуудын уламжлалт амьдралын хэв маягийг өөрчилж байна. Олон удаагийн ган, зуд, ажлын байрны хомсдол, мал аж ахуйгаас хамааралтай байдал, хүн амын амьжиргаа доройтох нэг шалтгаан болсоор байна. Үүнтэй зэрэгцэн хөдөөгөөс хөдөө рүү, хөдөөгөөс хот руу, хотоос хөдөө рүү чиглэсэн хөдөлгөөн нэмэгдэх болсон.

Орон нутгийн төр захиргааны байгууллагын удирдлагын зүгээс хүн амын богино хугацааны хөдөлгөөнтэй холбоотой анхдагч мэдээллийг бий болгох, түүнийг өөрсдийн орон нутгийн түвшинд тодорхой шийдвэр гаргахад ашиглах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байгаа талаар удаа дараа санал гаргаж байсан билээ.

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь Үндэсний Статистикийн Хороотой хамтран

Өмнөговь, Дундговь аймгийн хэмжээнд Богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааг 2021 онд амжилттай зохион байгуулсан. Олон улсад ДТМ аргачлалыг ашиглан энэ чиглэлийн судалгаануудыг хэд хэдэн орнуудад туршсан зохион байгуулсан байдаг. Бид өөрийн орны онцлог нөхцөл байдалд тохируулан энэхүү судалгааг улам өргөжүүлж 21 аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг НҮБ-ын ОУШХБ-аас санаачилсны дагуу 2022 онд анх удаа зохион байгууллаа.

Энэхүү судалгааны тайлангийн үр дүнг ашиглан цаашид энэ чиглэлээр хийгдэх богино хугацааны хөдөлгөөнийг тандах судалгааны үзэл баримтлал, ойлголт, тодорхойлолтыг гаргахад багахан ч гэсэн хувь нэмрээ оруулахад энэхүү судалгааны үр дүнгийн зорилго оршино.

1. СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааг 2022 оны 6, 7, 8 дугаар сард Монгол Улсын 21 аймгийн 1640 багийг хамарч нийт багийн засаг дарга нарын мэдлэгийн түвшинд тулгуурлан зохион байгуулсан болно. Энэ удаагийн судалгаа нь НҮБ-ын ОУШХБ болон ҮСХ-ны хамтарсан анхны богино хугацааны хөдөлгөөнийг тандах судалгаа байлаа. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааны нэг адил зарчмаар энэхүү судалгаа явагдсан бөгөөд хүн амын суурь үзүүлэлт, албан ёсны бүртгэл, шилжин ирэлт, явалт, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал зэрэг үндсэн 5 сэдвийн хүрээг хамарсан. Тухайн багийн засаг дарга нь орон нутгийнхаа хүн ам зүй болон шилжилт хөдөлгөөний талаар гүнзгий мэдээлэлтэй гэж үзсэн учраас мэдээлэл цуглуулагчаар багийн засаг дарга нарыг сонгосон. ОУШХБ-аас өмнө нь хийгдэж байсан судалгаагаар уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн хомсдол нь манай улсын уламжлалт шилжилт хөдөлгөөний хэв маягийг өөрчилж байгааг тогтоожээ. Зудын давтамж, хүндрэл ихсэх нь хөдөө орон нутгийн амь амьжиргаанд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй шилжилт хөдөлгөөнд шууд нөлөөлж байна.

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Судалгааны зорилго нь богино хугацааны хөдөлгөөнд орсон иргэдийн шалтгаан, хөдөлмөр эрхлэлт, тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг судлах замаар Монгол Улс дахь богино хугацааны хөдөлгөөнд оролцогчдод зориулсан бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгоход шаардлагатай мэдээллийг бий болгох явдал юм.

Энэхүү судалгааг явуулснаар хүн амын богино хугацааны хөдөлгөөний талаарх мэдээллийн эх үүсвэрийг бий болгож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг боловсруулж бодлого гаргагч, төлөвлөгч, шийдвэр гаргагч нарт шаардлагатай мэдээллийг өгч зорилтот бүлэгт

тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь гол ач холбогдол нь юм.

Туршилтын судалгаагаар ОУШХБ-ын Шилжилт хөдөлгөөнийг тандах матриц (DTM-displacement tracking methodology)-ын дагуу хөдөлгөөнд оролцож буй хүн амын хөдөлгөөн, тулгарч буй хүндрэл бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж гаргахад чиглэгдсэн болно.

1.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ОУШХБ-ын ДТМ судалгааны багаас боловсруулсан, Богино хугацааны хөдөлгөөнийг тандах аргачлалыг ашигласан болно. Богино хугацааны хөдөлгөөнийг тандах аргачлал нь хөдөлгөөнт хүн амын тоо, байршил, богино хугацааны хөдөлгөөнд оролцсон шалтгаан, хөдөлмөр эрхлэлт, орон нутагт тулгамдаж буй хүндрэлийг тодорхойлоход чиглэсэн юм. Мэдээллийг цуглуулахад голчлон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн байгууллага, хороо, хэсгийн ахлагч нарын мэдээлэл дээр үндэслэж, давхар баталгаажуулалт хийж цуглуулдаг юм. Энэхүү судалгаанд Багийн Засаг дарга нар гол мэдээлэгчээр ажиллаж, өөрсдийн мэдлэгийн хүрээнд мэдээллийг цуглуулж, маягтын дагуу программд мэдээллийг оруулсан.

Судалгааны асуулга, үзүүлэлтүүдийг ОУШХБ-аас тусгайлан боловсруулсан загвараар агуулгыг өөрчилж утгыг алдагдуулахгүй хэвээр нь авч ашигласан.

Судалгааны асуулга нь дараах 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хаягийн хэсэг
2. Хүн ам, өрхийн мэдээлэл
3. Богино хугацааны хөдөлгөөний мэдээлэл (ирсэн)
4. Тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээл
5. Богино хугацааны хөдөлгөөний мэдээлэл (явсан)

Асуулгын хуудасны дэлгэрэнгүйг (Хавсралт А)-аас харна уу.

1.3 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Судалгааны маягт, программ холбоосыг багийн засаг дарга нарт и-мэйл хаягаар нь хүргүүлж судалгааны мэдээллийг цуглуулсан.

Уг үйл ажиллагааны хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Мэдээлэл цуглуулж эхлэхээс 7 хоногийн өмнө багийн засаг дарга нарт сургалт зохион байгуулж, мэргэшүүлэх ба нийт 14 хоногийн турш ажиглалт хийж, холбогдох нэгжээс мэдээлэл цуглуулсан.
2. Судалгааны багийнхан мэдээлэл цуглуулах явцад асуулгыг үнэн зөв, бүрэн авсан эсэхэд болон кодлолтод хяналт хийсэн.
3. Судалгааны багийнхан цуглуулсан мэдээллийг шалгаж, хагас нээлттэй асуултын

хариултаудыг кодлон, баталгаажуулж судалгааг эцэслэсэн.

1.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээллийг шалгах, үр дүнг боловсруулах программ хангамжийн бодлогын даалгаврыг ОУШХБ болон ҮСХ хамтран боловсруулсан.

Үүнд:

1. Судалгааны мэдээллийг вебд суурилсан КОВО программаар цуглуулсан.
2. Судалгааны мэдээллийг шалгах, дахин тодруулга хийж, засварлах ажлыг ҮСХ-ны судалгааны баг хийсэн.
3. Судалгааны мэдээлэл боловсруулалтад SPSS программыг ашиглалаа.

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



1.5 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хүн амын суурь мэдээлэл: Судалгааны үед тухайн байршилд оршин суугчид нь гарал, үүсэл, бичиг баримт, бүртгэл, нас, нийгэм, хүн ам зүйн бусад шинж чанараас үл хамааран оршин сууж байгаа иргэдийг хамруулна.

Өрх: Нэг байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрлийн болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.

Ирсэн хүмүүс: Тухайн аймаг доторх өөр газраас ирсэн эсэхээс үл хамааран дөрвөн долоо хоногоос доошгүй хугацаагаар оршин суух зорилготой тухайн газар ирсэн иргэдийг хамарна.

Явсан хүмүүс: Тухайн аймаг доторх өөр газар, аймгаас гадуур хаа нэг газар явсан эсэхээс үл хамааран дөрвөн долоо хоногоос доошгүй хугацаагаар нутаг буцах бодолгүй байгаа иргэдийг хамааруулна.

Гол мэдээлэгч: Энэ тохиолдолд багийн засаг дарга нарт хамааралтай мэдээллийн шинжээч эх сурвалжийг хэлнэ.

Тоологч: Мэдээлэл цуглуулдаг хувь хүн. Энэхүү судалгаанд мэдээлэл цуглуулах ажлыг гол мэдээлэгч

гүйцэтгэсэн тул хоёр нэр томъёо давхцаж байгаа юм.

Аймаг: Аймаг нь Монгол Улсын засаг захиргааны, нутаг дэвсгэрийн хуваарийн хамгийн том үндсэн нэгж юм. Аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд сумд хуваагддаг.

Сум: Сум нь Монголын засаг захиргааны хоёрдугаар түвшний нэгж юм.

Отор нүүдэл: Өвс, бэлчээрийн сайныг дагаж нүүдэллэн малаа таргалуулах

Эргэн ирсэн иргэд: Өөрийн төрсөн нутаг, эх орноос өөр газар тодорхой хугацаагаар амьдарч байгаад эх орон/төрсөн газартаа эргэн ирэх

2. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

2.1 СУДАЛГААНЫ ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдагчдыг хүн ам зүйн байдлаар авч үзэхэд (2022 оны 6, 7, 8-р сар) нийт 504 554 өрхийн 1 779 600 хүн хамрагдсан байгаагийн 893.9 мянга буюу 50.2 хувь нь эмэгтэйчүүд, 885.7 мянга буюу 49.8 хувь нь эрэгтэйчүүд байна. Нэг өрх дунджаар

3.6 буюу ам бүлтэй байна. Нийгмийн зарим үзүүлэлтүүдээс дурдахад нийт хүн амын 60 607 нь буюу 3.4 хувь нь тусгай хэрэгцээт иргэд байгаа бол судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 18 483 нь буюу 2.1 хувь нь жирэмсэн эмэгтэйчүүд байна.



504,554

Өрх



1,779,600

Хүн ам



50,2%

Эмэгтэйчүүд



36%

Насанд хүрээгүй хүүхдүүд



60,607

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд



40,261

Ганц бие иргэдийн тоо



18,483

Жирэмсэн эмэгтэйчүүд



24,505

Нийт өнчин хүүхдийн тоо



79,103

Өрх толгойлсон эцэг эхтэй өрхийн тоо




96,486

60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн тоо

Мөн өндөр настай асран хамгаалах хүнгүй 60 ба түүнээс дээш насны иргэд нийт ахмад настай иргэдийн 28.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 24 505

өнчин хүүхдүүд бүртгэлтэй байна гэж судалгаагаар мэдээлэгдсэн байна.


Зураг 2.1.2. Судалгаанд хамрагдагчид насны бүлэг, хувиар 2022 он



Судалгаанд хамрагдагчдыг насны бүлгээр авч үзэхэд нийт хүн амын 649.0 мянга буюу 36.5 хувийг 18 ба түүнээс доош насны насанд хүрээгүй иргэд, 988.7 мянга буюу 55.6 хувийг 18-59 насны иргэд, 141.9 мянга буюу 7.9 хувийг 60 ба түүнээс дээш насны ахмад настай иргэд тус тус эзэлж байгааг (Зураг 2.1.2)-оос харна уу.

Монгол Улсын хэмжээнд нийт 1 640 баг бүртгэлтэй байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын дүнд эзлэх хувийг аймаг тус бүрээр дараах (Зураг 2.1.3)-т харуулав. Энэхүү зургаас харахад хамгийн их хүн ам бүртгэгдсэн аймгууд нь Хөвсгөл (7.8 хувь), Өвөрхангай (6.7 хувь), Баян-Өлгий (6.3 хувь), Сэлэнгэ (6.2 хувь), Орхон, Дархан-Уул (6.0 хувь), Ховд, Төв, Архангай (5.4 хувь), Увс (4.8 хувь), Дорнод (4.6 хувь), Баянхонгор (4.5 хувь), Хэнтий (4.5 хувь), Завхан (4.2 хувь), Өмнөговь (4.1 хувь), Дорнод (4.0 хувь), Сүхбаатар (3.7 хувь), Булган (3.5 хувь), Говь-Алтай (3.3 хувь), Дундговь (2.4 хувь), Говьсүмбэр (1.0 хувь) аймгууд байна.

Зураг 2.1.3 Судалгаанд хамрагдсан нийт хүн амд эзлэх хувь, 2022 он



Харин хүн ам бага бүртгэгдсэн аймгууд нь Сүхбаатар (3.7 хувь), Булган (3.5 хувь), Говь-Алтай


(3.3 хувь), Дундговь (2.4 хувь), Говьсүмбэр (1.0 хувь) тус тус эзэлж байна.

2.2 АЛБАН ЁСНЫ БҮРТГЭЛ

Улсын хэмжээнд албан ёсны бүртгэлтэй анхан шатны засаг захиргааны хамгийн бага нэгж болох нийт багуудыг тухайн харьяалах нэгжийн багийн засаг дарга нар оршин сууж байгаа иргэдийг өөрсдийн үнэлэлт мэдлэгийн хүрээнд бүртгэсэн байдлыг дараах (Зураг 2.2.1)-т харуулав. Доорх зургаас харахад хөдөө орон нутгийн нийт 1 640 багаас 664

нь буюу 40.5 хувь нь албан ёсны бүртгэл хийлгэдэг гэж хариулсны дотор тэдний 83.1 хувь нь бүртгэлээ бүрэн сайн хийлгэдэг гэж хариулжээ. Мөн ихэнх нь бүртгэлтэй гэж 14.3 хувь, тал нь бүртгэлтэй гэж 0.9 хувь, бараг бүртгэлгүй гэж 0.8 хувь, бүгд бүртгэлгүй гэж 0.5 хувь, зарим нь бүртгэлтэй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 2.2.1 Албан ёсны бүртгэлтэй багууд, дүнд эзлэх хувиар, 2022 он



Нийт багуудын хэмжээнд хүн бүр нь 100.0 хувь бүртгэлтэй гэж хариулсан аймгуудыг хамгийн их

бүртгэлтэй байдлаар нь Зураг 2.2.2-т харуулав.

Зураг 2.2.2 Хүн бүр бүртгэлтэй (100.0%), 2022 он



Зураг 2.2.3 Бүгд бүртгэлгүй (0.0%), 2022 он



Эндээс харахад хамгийн өндөр хувь эзэлж байгаа 5 аймгийн эхэнд Ховд (58.2 хувь), Говь-Алтай (58.0 хувь), Дорноговь (50.8 хувь), Дундговь (47.1 хувь), Баян-Өлгий (47.0 хувь)-ийг эзэлж байна. Харин Зураг 2.2.3-т нийт албан ёсны бүртгэлээ хийлгэдэг аймгуудаас бүгд бүртгэлгүй гэж хариулсан аймгуудыг авч үзсэн. Нийт 1 640 багаас 8 нь буюу 0.5 хувь нь огт бүртгэлгүй гэж хариулсны дотор Говьсүмбэр (10.0 хувь), Өмнөговь (1.7 хувь), Дорнод, Дундговь (1.5 хувь), Булган (1.3 хувь), Говь-Алтай, Увс (1.1 хувь), Төв аймаг (1.0 хувь)-ийг тус тус эзэлж байна.

Судалгаанд хамрагдагчдыг бүртгэлээ хийлгэдэггүй голлох шалтгаанаар авч үзэхэд түр зуур оршин сууж байгаа болохоор бүртгүүлэхийг хүсдэггүй гэж 23.6 хувь, шалтгаан байхгүй гэж 17.2 хувь, хэрхэн бүртгүүлэхээ мэдэхгүй гэж 15.5 хувь, бүртгэл хийлгээд ямар нэгэн ашиг тус байхгүй гэж 13.7 хувь, боловсролын шалтгаанаар гэж 9.9 хувь, хэтэрхий төвөгтэй, хугацаа их шаарддаг гэж 5.9 хувь нь хариулсан ба тэдгээрийн 3.2-5.6 хувь нь иргэний бүртгэлийн газраас хол байдаг, хэт их мэдээлэл шаарддаг гэж үзсэн бол үлдсэн 5.4 хувь нь өөр бусад шалтгаанаас болсон гэж хариулсан байна.

Зураг 2.2.4 Бүртгэлээ хийлгэдэггүй голлох шалтгаан, хувиар, 2022 он



Багийн засаг дарга нар багийнхаа иргэдийн орлогын эх үүсвэрийг өөрсдийн бодлоор дүгнэхдээ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс 61.5 хувь, цалин хөлсний орлогоос 22.7 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн орлогоос 7.4 хувь, газар болон байрны

түрээсийн орлого, гэр бүл, найз нөхдөөс илгээсэн мөнгөн тусламж 0.1 хувь, төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж, тэтгэврийн орлогоос 0.1-1.0 хувь гэж хариулсан бол үлдсэн 7.0 хувь нь эдгээрээс бусад өөр эх үүсвэрээс гэж хариулсан байна.

2.3 САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монголын хөдөө орон нутгийн хэмжээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хамгийн чухал эх үүсвэрийн нэг бөгөөд нийт багийн засаг дарга нарын 61.5 хувьд нь хариулсан байна. Цалин хөлсний орлогоос гэж 22.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэлт гэж 7.4

хувь нь, тэтгэвэр гэж 1.0 хувь нь бусад буюу үлдсэн хувь нь 7.4 хувь доорх бусад эх үүсвэрээс орлогоо бүрдүүлдэг гэж хариулсныг Зураг 2.3.1-ээс харах боломжтой.


Зураг 2.3.1 Багийн иргэдийн орлогын эх үүсвэр, хувиар 2022 он



Багийн засаг дарга нараас сүүлийн 3 сарын хугацаанд өрхүүд хүнсний хэрэглээгээ хэр их багасгасан талаар тодруулахад дунд зэрэг гэж бараг тал хувийг

буюу 50.1 хувь нь хариулсан бол маш их, их гэж 11.5-25.9 хувь нь хариулсан бол бага гэж 11.1 хувь нь, маш бага гэж 1.5 хувь нь хариулсан байна.

Зураг 2.3.2 Хүнсний хэрэглээгээ багасгасан байдал, хувиар, 2022 он



2.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Монголчуудын уламжлалт нүүдэлчин ахуй соёл иргэншлийг харуулах салбар нь хөдөө аж ахуйн салбар юм. Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар багийн засаг

дарга нарын мэдээлснээр авч үзэхэд мөн адил хамгийн их буюу 64.3 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байгаа нь дараах зургаас харагдаж байна.

Зураг 2.4.1 Хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хувиар, 2022 он



Мөн боловсролын салбарт (6.6%), үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт (6.0%), уул уурхайн олборлолтын салбарт (3.6%), төрийн удирдлага, батлан хамгаалахын салбарт (3.1%) нь тус тус ажиллаж байна. Барилгын салбарт, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засварын салбарт (1.2%-1.6%), боловсруулах үйлдвэрлэлт, цахилгаан, ус хангамжийн салбарт (0.5%) нь ажиллаж байгаа гэж хариулсан бөгөөд үлдсэн нь буюу 12.3

хувь нь өөр бусад салбаруудад ажилладаг гэжээ.

Нийт багийн засаг дарга нараас тухайн иргэдэд хангалттай хүртээмжгүй байгаа үйлчилгээг нэрлүүлэхэд (3 хүртэлх сонголттой хариулттай) 21 аймгийн багийн засаг дарга нар 1-рт эрүүл мэндийн үйлчилгээ (20.7%), 2-рт усан хангамж (16.6%), 3-рт ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ (13.4%) хувийг эзэлж байгаа гэж хариулсан байна.


Зураг 2.4.2 Багийн иргэдэд хангалттай хүртээмжгүй байгаа үйлчилгээ



Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан арга хэмжээг авч үзэхэд тусгайлан эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хэмээн 44.3 хувь нь буюу хамгийн их хувийг хариулжээ. Харин 30.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь анхаарал татах асуудал юм. Нийгмийн чухал энэхүү асуудлыг мэдэхгүй байгаа засаг дарга

нар байгаа гэж үзвэл энэ талын мэдлэг мэдээлэл олгох, тэднийг хийж байгаа авч хэрэгжүүлж буй ажлууддаа татан оролцуулж байх хэрэгцээ байгааг нотолно. Мөн ямар үйлчилгээ явуулж буй нь тодорхой бус ойлгомжгүй гэж бодож хариулсан байх талтай.

Зураг 2.4.3 Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан арга хэмжээ, 2022 он




3. БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛГӨӨН (ИРСЭН)

Богино хугацааны шилжих хөдөлгөөнийг тандах туршилтын судалгаагаар сүүлийн 3 сарын хугацаанд тухайн багт ирсэн хүмүүс байгаа эсэхийг тодруулсан. Ингэхэд Орхон аймагт 100.0 хувь ирсэн

хүмүүс байгаа гэж хариулсан байна. Мөн Дархан-Уул 96.2 хувь, Сэлэнгэ аймаг 78.9 хувь, Төв аймаг 74.2 хувь, Хэнтий аймаг 71.9 хувь, Сүхбаатар 71.6 хувийг тус тус хамгийн их ирсэн гэж хариулжээ.


Зураг 3.1 Сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн хүн байгаа эсэх, хувиар, 2022 он




Нийт 31,664 хүн сүүлийн 3 сарын хугацаанд Монгол Улсын хөдөө орон нутагт ирсэн гэж энэхүү туршилтын судалгаагаар хариулсан бөгөөд үүнээс хамгийн өндөр хувь эзэлж байгаа 5 аймгийг онцолж дараах зурагт харуулав. Эндээс харахад хамгийн их

хувийг Өмнөговь аймаг (16.2 хувь), Архангай аймаг (8.2 хувь), Орхон аймаг 6.1 хувь, Дорнод аймаг (6.0 хувь), Өвөрхангай аймаг (5.8 хувь) тус тус эзэлж байна.

Зураг 3.2 Богино хугацааны хөдөлгөөнөөр ирсэн хүмүүс, хувиар хамгийн өндөр 5 аймгаар, 2022 он



Зураг 3.3 Тухайн багт сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн хүмүүс, хувиар 2022 он




Мөн Архангай, Орхон, Дорнод, Өвөрхангай, Хөвсгөл, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Төв аймгуудад 5.0-8.2 хувь ирсэн гэж хариулсан байгаа нь мөн их хувийг эзэлж байна.

Багийн засаг дарга нараас сүүлийн 3 сарын хугацаанд

тус орон нутагт ирсэн иргэд хаанаас ирсэнийг тодруулахад бусад сум, багаас гэж хариулсан нь хамгийн их 48.6 хувь, Улаанбаатар хотоос 35.8 хувь, өөр аймгаас 14.4 хувь нь ирсэн бол үлдсэн 1.2 хувь нь гадаадаас ирсэн иргэд эзэлж байна.


Зураг 3.4 Сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн хүмүүс, хувиар, 2022 он



Судалгаанд хамрагдагчдаас өөр аймгаас ирсэн бол аль аймгаас ирсэнийг асууж тодруулсан ба хамгийн их хувийг Хөвсгөл аймаг 7.9 хувь, Завхан аймаг 7.1 хувь, Өвөрхангай аймаг 6.8 хувь, Баянхонгор аймаг 6.4 хувь, Архангай аймаг 6.2 хувь, Баян-Өлгий 6.4

хувийг тус тус эзэлж байна. Харин хамгийн бага хувийг Дархан-Уул аймаг 1.6 хувь, Орхон аймаг 1.5 хувь, Говьсүмбэр аймаг 0.6 хувийг тус тус эзэлж байгааг (Зураг 3.5)-аас харна уу.


Зураг 3.5 Ирсэн аймгуудаар, хувиар, 2022 он



Сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн иргэдийг үндсэн шалтгаанаар нь авч үзэхэд хөдөлмөр эрхлэх шалтгаанаар хамгийн их буюу 32.6 хувь нь ирсэн гэж хариулсан ба гэр бүлийн шалтгаанаас 19.7 хувь, боловсролын шалтгаанаас 13.5 хувь, отор нүүдэл, баяр ёслол (хурим, амралт)-оос 12.0 хувь,

анхан шатны тусламж үйлчилгээ авах 0.7 хувь, эрүүл мэндийн шалтгаанаас 0.4 хувь, онцгой нөхцөл байдал (Ковид-19 цар тахал)-аас 0.2 хувь, бусад шалтгаанаас гэж 8.9 хувь хариулсныг дараах зургаас харна уу.

Зураг 3.6 Сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн хүмүүсийн үндсэн шалтгаан, хувиар, 2022 он



Сүүлийн 3 сарын хугацаанд хөдөлмөр эрхлэх шалтгаанаар ирсэн хүмүүсийн ихэнх нь аль салбарт ажиллаж байгааг тодруулахад хамгийн их буюу 38.7 хувийг ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллаж буй ажиллагсад, барилгын салбарт ажиллаж байгаа ажиллагсад 12.1 хувь, боловсролын салбарт ажиллаж байгаа ажиллагсад 11.1 хувь,

үйлчилгээний бусад үйл ажиллагаанд ажиллаж байгаа ажиллагсад 9.8 хувь, уул уурхайн олборлолтын салбарт ажиллаж байгаа ажиллагсад 8.6 хувь эзэлж байна. Хамгийн бага хувийг боловсруулалтын салбар болон мэдээлэл холбооны салбарт ажиллаж буй ажиллагсад эзэлж байна.

Зураг 3.7 Сүүлийн 3 сарын хугацаанд хөдөлмөр эрхлэх шалтгаанаар ирсэн хүмүүс, эдийн засгийн салбараар, хувиар, 2022 он



Сүүлийн 3 сарын хугацаанд уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэхээр ирсэн хамгийн их 5 аймгийг дараах зурагт харуулав. Өмнөговь аймагт уул уурхай нүүрс тээвэрлэлтийн чиглэлийн олон аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдагтай холбоотойгоор


хамгийн их буюу 79.1 хувь нь хөдөлмөр эрхлэхээр очсон байна. Хоёрдугаарт Дорнод аймаг, 4.3 хувь, гуравдугаарт Архангай аймаг 3.2 хувь, дөрөвдүгээрт Хэнтий аймаг 3.0 хувь, тавдугаарт Завхан аймаг 1.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 3.8 Сүүлийн 3 сарын хугацаанд уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэхээр ирсэн иргэд, хувиар, 2022 он




Сүүлийн 3 сарын хугацаанд малчнаар ажиллах ирсэн хүний тоог авч үзвэл хамгийн их нь Хэнтий аймагт 18.6 хувь нь ажиллахаар иржээ. Үүний дараа Төв аймагт 14.6 хувь, Сүхбаатар аймагт 12.9 хувь, Дорнод аймагт 10.1 хувь, Сэлэнгэ аймагт хамгийн

Зураг 3.9 Сүүлийн 3 сарын хугацаанд малчнаар ажиллахаар ирсэн иргэд, хувиар, 2022 он



бага буюу 7.6 хувь малчнаар ажиллахаар очжээ. Сүүлийн 3 сарын хугацаанд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэхээр ирсэн хүүхдийн тоо (15-17 нас) хамгийн их хувь эзэлж байгаа 5 аймгаар авч үзлээ.

Зураг 3.10 Сүүлийн 3 сарын хугацаанд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэхээр ирсэн хүүхэд (15-17 нас), хамгийн их 5 аймаг, хувиар, 2022 он




Энэ хугацаанд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэхээр ирсэн хүүхдийн хамгийн их хувийг Хэнтий аймаг 12.7 хувь, Төв аймаг 9.8 хувь, Сэлэнгэ аймаг 8.6 хувь, Дорноговь аймаг, Сүхбаатар аймаг тус бүр 6.3 хувийг эзэлж байгаа нь бусад аймгаас өндөр хувийг эзэлж байна.

Зураг 3.11 Сүүлийн 3 сар отор нүүдэл хийхээр ирсэн иргэд хамгийн их 5 аймаг, хувиар, 2022 Он



Сүүлийн 3 сар отор нүүдэл хийхээр ирсэн иргэдийг хамгийн их 5 аймгаар нь авч үзвэл Баянхонгор аймагт ирсэн иргэд хамгийн их буюу 19.5 хувь, Дундговь аймагт ирсэн иргэд 15.4 хувь, Ховд аймагт ирсэн иргэд 14.0 хувь, Өвөрхангай аймагт ирсэн иргэд 10.6 хувь, Хөвсгөл аймагт ирсэн иргэд 9.7 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 3.12 Сүүлийн 3 сарын хугацаанд отор нүүдлээр ирсэн хүмүүсийн үндсэн шалтгаан, хувиар, 2022 он



Сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн отор нүүдлээр ирсэн хүмүүсийн үндсэн шалтгааныг авч үзэхэд нийт ирсэн хүн амын хамгийн их буюу 41.4 хувь нь бэлчээрийн гарц сайн учраас, 40.5 хувь нь өөрийн

багт ган, зуд нүүрлэсэн учраас, 11.2 хувь нь улирлын чанартай хөдөлгөөнд оролцдог учраас, үлдсэн 6.9 хувь нь бусад шалтгаанаас хамаарч ирсэн гэж хариулжээ.

Зураг 3.13 Сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн иргэдээс багтаа үлдсэн иргэд, хувиар, 2022 он



Сүүлийн 3 сарын хугацаанд ирсэн иргэдээс багтаа үлдсэн иргэдийг хамгийн их 5 аймгаар авч үзэхэд Өвөрхангай аймагт хамгийн их буюу 10.6 хувь нь,


Орхон аймагт 10.3 хувь, Өмнөговь аймагт 8.8 хувь, Баянхонгор аймагт 7.4 хувь, Дархан-Уул аймагт 7.2 хувь нь тус тус ирсэн байна.

4. ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Богино хугацааны хөдөлгөөнөөр ирсэн хүн ам тухайн багт хүндрэл бэрхшээл учруулж байна уу? гэсэн асуултад Дархан-Уул аймгийн багийн засаг дарга нар хамгийн их 50.0 хувь нь тийм гэж хариулжээ. Мөн Төв аймгийн багийн засаг дарга нар 34.0 хувь, Хэнтий аймгийн багийн засаг дарга нар 28.1 хувь, Орхон аймгийн багийн засаг дарга нар

28.0 хувь, Дорнод аймгийн багийн засаг дарга нар 26.9 хувь, Ховд аймгийн багийн засаг дарга нар 23.1 хувь, Сүхбаатар аймгийн багийн засаг дарга нар 22.4 хувь, Говьсүмбэр аймгийн багийн засаг дарга нар 20.0 хувь нь тус тус хүндрэл учруулдаг гэж хариулсан нь дараах зургаас харагдаж байна.


Зураг 4.1 Танай багт богино хугацаагаар ирж буй хүн амын хөдөлгөөн хүндрэл бэрхшээл учруулж байна уу? Аймаг, хувиар, 2022 он



Бусад аймгууд 20.0 хувиас доош хувиар хүндрэл учруулдаг буюу бага зэрэг хүндрэл учруулдаг гэж хариулсан байна. Хүндрэл бэрхшээл учруулахгүй байгаа гэж хариулсан аймгуудыг авч үзэхэд хамгийн

их буюу Баян-Өлгий аймгийн багийн засаг дарга нар 95.0 хувь нь үгүй буюу хүндрэл учруулахгүй байгаа гэж үзсэн байна.


Зураг 4.2 Богино хугацаагаар ирж буй хүн амын хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудал, хувиар, 2022 он



Богино хугацааны хөдөлгөөнөөр ирж буй иргэдийн хөдөлгөөнтэй холбоотой гарч буй тулгамдаж буй асуудлыг авч үзэхэд нийт хариулагчдын хүрээлэн буй орчны бохирдол 25.1 хувь, цөлжилт бэлчээрийн даац 21.2 хувь, боловсролын үйлчилгээний ачаалал

17.2 хувь, гэмт хэрэг хулгай дээрэм 15.6 хувь, эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал 14.6 хувь, үлдсэн 6.2 хувь нь бусад шалтгаанаас болж тулгамдаж буй асуудал болж байна гэж хариулжээ.

Зураг 4.3 Дээрх асуудлыг арилгах, урьдчилан сэргийлэх талаар багийн засаг захиргааны нэгжээс ямар нэгэн арга хэмжээ авч байна уу? Аймаг, хувиар, 2022 он



Дээрх асуудлыг арилгах талаар, урьдчилан сэргийлэх талаар багийн засаг захиргааны нэгжээс ямар нэгэн арга хэмжээ авч байна уу? гэсэн асуултад Баян-Өлгий, Булган аймаг хамгийн их буюу 100.0 хувь тийм арга хэмжээ авч байгаа гэж хариулжээ. Мөн Өвөрхангай аймагт ямар нэг арга хэмжээ авч

байгаа гэж хариулсан нь 96.0 хувийг эзэлж байна. Говьсүмбэр аймагт арга хэмжээ авахгүй байгаа буюу 50.0 хувь нь үгүй гэж хариулсан бол мөн Завхан аймаг 35.3 хувь үгүй гэж хариулсан нь их хувийг эзэлж байгааг дээрх зургаас харах боломжтой.

Зураг 4.4 Орон нутгийн засаг захиргааны нэгжээс одоо авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс өөр ямар арга хэмжээ авахыг илүүд үзэж байна вэ? Хувиар, 2022 он




Орон нутгийн засаг захиргааны нэгжээс одоо авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс өөр ямар арга хэмжээ авахыг илүүд үзэж байна вэ? гэсэн асуултад хамгийн их буюу 62.6 хувь нь богино хугацааны хөдөлгөөнийг бүртгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэж хариулсан ба мөн төвлөрсөн бүсийн орох, гарах хөдөлгөөний хяналтыг сайжруулах шаардлагатай гэж 15.3 хувь, орон нутаг хоорондын тээврийн хэрэгслээр үйлчлүүлж буй иргэдийн мэдээллийг бүртгэх шаардлагатай байна гэж 10.3 хувь нь хариулсан бол үлдсэн буюу бусад арга хэмжээнүүдийг авахыг илүүд үзэж байна гэж 11.8 хувь нь хариулсан байна.

5. БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ (ЯВСАН)


Нийт 35,081 хүн сүүлийн 3 сарын хугацаанд Монгол Улсын хөдөө орон нутаг хооронд явсан гэж туршилтын судалгаагаар хариулсан байгаа бөгөөд үүнээс хамгийн өндөр хувь эзэлж байгаа 5 аймгийг онцолж дараах зурагт харуулав. Эндээс

харахад хамгийн өндөр хувийг Орхон (13.7 хувь), Өвөрхангай (9.6 хувь), Баянхонгор (9.3 хувь), Говь-Алтай (8.2 хувь), Архангай (6.9) хувийг тус тус эзэлж байна.

Зураг 5.1 Танай багаас сүүлийн 3 сарын хугацаанд явсан иргэд бий эсэх, аймаг, хувиар, 2022 он




Зураг 5.2 Богино хугацааны хөдөлгөөнөөр явсан хүмүүс, хамгийн өндөр 5 аймгаар, хувиар 2022 он




Судалгаанд хамрагдагчдаас сүүлийн 3 сарын хугацаанд явсан хүмүүсийн ихэнх нь хаашаа явсныг тодруулахад нийт хариулагчдын дийлэнх нь буюу 58.6 хувь нь Улаанбаатар хот руу, бусад сум баг руу 27.8 хувь, өөр аймаг руу 10.3 хувь, гадаад руу гэж 3.3 хувь нь хариулсан байна.

Зураг 5.3 Танай багаас сүүлийн 3 сарын хугацаанд явсан хүмүүсийн ихэнх нь хаашаа явсан бэ? хувиар, 2022 он



Харин бусад сум баг руу явсан бол тэдгээрийн дийлэнх нь хаашаа явсныг тодруулахад нийт хариулагчдын дийлэнх нь буюу 54.1 хувь нь аймгийн төвийн баг руу, сумын төвийн баг руу 30.5 хувь нь, хөдөөгийн баг руу 15.4 хувь явсан гэж хариулжээ.

Зураг 5.4 Хэрэв бусад сум, баг руу явсан бол тэдгээр хүмүүсийн ихэнх нь хаашаа явсан бэ? хувиар, 2022 он



Сүүлийн 3 сарын хугацаанд явсан иргэдийн үндсэн шалтгааныг багийн засаг дарга нараас тодруулахад хөдөлмөр эрхлэхээр 29.3 хувь, боловсролын шалтгаанаар гэж 24.8 хувь хариулсан нь хамгийн их хувийг эзэлж байна. Мөн гэр бүлийн шалтгаанаар хөдөө орон нутаг руу ихээхэн хөдөлгөөнд оролцдог нь харагдаж байгаа ба 19.0 хувийг, эрүүл мэндийн шалтгаанаар 11.2 хувь, отор нүүдлийн шалтгаанаар 6.5 хувь, анхан шатны тусламж үйлчилгээ авах шалтгаанаар 2.6 хувь, баяр ёслол (хурим, амралт)-ын шалтгаанаар 2.3 хувь, онцгой нөхцөл байдал (Ковид-19 цар тахал)-ын шалтгаанаар 0.2 хувь, үлдсэн 4.1 хувь нь дээрхээс бусад шалтгаанаар явсан гэж хариулсан байгааг (Зураг 5.5)-аас харна уу.

